



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2003 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

КОМИССЫН ДҮНГ БАТЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2002 оны 5/29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Нийслэлийн Засаг даргын 2003 оны 282 дугаар захирамжаар байгуулагдсан Тендерийн комиссын үнэлгээний тайланг хэлэлцээд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Нийслэлийн Орон сууц нийтийн аж ахуйн газрын харъяа Сүхбаатар дүүргийн "Усны гудамж-Өргөө", Баянгол дүүргийн 4 дүгээр хорооллын "Их нарлаг-Өргөө", 10, 2 дугаар хорооллын "Баянгол-Өргөө" салбарын, Баянзүрх дүүргийн 13, 16 дугаар хорооллын "Алтан тэвш-Өргөө" салбарын менежментийн гэрээгээр ажиллуулах багийг сонгон шалгаруулах тендерийн комиссын дүнг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тендерт шалгарсан багтай холбогдох хууль журмын дагуу энэ оны 9 дүгээр сард багтааж менежментийн гэрээ байгуулж, өмч хөрөнгийг хүлээлгэн өгч, гэрээний хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/, Нийслэлийн Орон сууц нийтийн аж ахуйн газар /Г.Мөнхбаяр/-т тус тус үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН ДАРГА


Т.БИЛЭГТ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨ-  
ЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ-  
ДИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.МАНАЛЖАВ

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД

П.АЛТАНЦЭЦЭГ  
Т. БАДАМЖУНАЙ  
Д.БААСАНСҮРЭН  
Ц.БААТАРСАЙХАН  
С.НЯМЗАГД  
У.УЛАМБАЯР  
Г.ЭНХТҮВШИН



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны  
121- дугаар тогтоолын хавсралт

### ТЕНДЕРИЙН КОМИССЫН ДҮН

№	ОСНААГ-ын нэр	Тендерт ялагч
1	СБД-ийн "Усны гудамж-Өргөө" салбар	Иргэн Т.Болорчулууны баг
2	БГД-ийн "Их нарлаг-Өргөө" салбар	Иргэн О.Алтантулгын баг
3	БГД-ийн 10 дугаар хорооллын "Баянгол-Өргөө" салбар	Иргэн П.Отгонбаярын баг
4	БГД-ийн 2 дугаар хорооллын "Баянгол-Өргөө" салбар	Иргэн Г.Эрдэнэцэцэгийн баг
5	БЗД-ийн 13 дугаар хорооллын "Алтан тэвш-Өргөө" салбар	Иргэн С.Наранцэцэгийн баг
6	БЗД-ийн 16 дугаар хорооллын "Алтан тэвш-Өргөө" салбар	"Эцэцг эх" ХХК